

Өргөн нэвтрүүлгийн эзэмшил, давхар эзэмшил, тэдгээрийн зах зээлийн нөхцөл байдал болон эзэмшил, гадаадын хөрөнгө оруулалт, хэт төвлөрлөөс сэргийлэхтэй холбоотой зохицуулалтын хэрэгжилтэд хийсэн үнэлэлт дүгнэлт

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийг Монгол Улсын Их Хурал 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдөр баталж, 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх эрх зүйн үндсийг тодорхойлж, зах зээлийн шударга өрсөлдөөний таатай орчныг бүрдүүлэх, үндэсний болон нийтийн ашиг сонирхолд нийцсэн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж байна.

Тус хуулиар өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх эрх зүйн үндсийг бүрдүүлэх, зах зээлд шударга өрсөлдөөний орчныг төлөвшүүлэх, үндэсний болон нийтийн ашиг сонирхолд нийцсэн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг хөгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан. Мөн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшил, давхар эзэмшил, гадаадын хөрөнгө оруулалт, зах зээлийн хэт төвлөрлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн зохицуулалтыг тусган, өрсөлдөөний тэнцвэртэй орчин, хэвлэл мэдээллийн олон ургалч байдлыг хангах, **иргэдийг олон талт, тэнцвэртэй мэдээ, мэдээллээр хангах** эрх зүйн үндсийг бий болгосон. Энэхүү үнэлгээг нь дээрх зохицуулалтын хэрэгжилтийн **байдал**, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшил, давхар эзэмшил, гадаадын хөрөнгө оруулалт болон зах зээлийн нөхцөл байдалд хийсэн судалгаа, дүн шинжилгээнд үндэслэн боловсруулсан болно.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд өргөн нэвтрүүлгийн талаар бодлого боловсруулж, зохицуулалт хийхдээ *олон нийтийн нийтлэг эрх ашигт нийцсэн, тэнцвэртэй, бодит мэдээ, мэдээлэл олж авах иргэний эрхийг хангах, олон ургалч үзэл бодлыг хүндэтгэх, өргөн нэвтрүүлгийг эзэмшлийн хэт төвлөрлөөс хамгаалах* болон зах зээлийн өрсөлдөөний таатай орчныг бүрдүүлэх зарчмыг баримтлахаар тусгаж, **салбарын онцлог зохицуулалт** болох эзэмшлийн хэт төвлөрлөөс хамгаалах, урьдчилан сэргийлэх агуулгыг хуульчилсан.

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг хэвлэл мэдээллийн хэрэгслийн нэг төрөл, стратегийн ач холбогдолтой, тэргүүлэх салбар гэж тодорхойлж, хэвлэн нийтлэх, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах иргэний эрхийг хангах, олон ургалч үзэл санааг бий болгох зэрэг ардчиллын суурь зарчмыг төлөвшүүлэхэд чухал оролцоотой гэж үздэг. Үүнтэй холбогдуулан Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.3.4.3-т хэвлэл мэдээллийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэхийг нийгмийн тогтвортой байдлыг хангах нэг чиглэл болгон тусгасан байдаг.

Иймд олон улсад тухайн зах зээлд шударга өрсөлдөх нөхцөл бүрдүүлэх, ардчиллын суурь зарчмыг хангах зорилгоор өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийн тоо, хувьцаа эзэмшил, эцсийн өмчлөгч, эзэмшлийн болон зах зээлийн төвлөрлийн асуудал, зах зээлд эзлэх хувь хэмжээнд анхаарч зохицуулалт хийдэг байна.

Харилцаа холбооны зохицуулах хороо нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд өргөн нэвтрүүлгийг хараат бус, нээлттэй, ёс зүйтэй байлгах зорилгоор өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшлийг жил бүр шинэчлэн гаргуулан авч, олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлэн ажиллаж байна.

Өнөөгийн нөхцөл байдал:

Манай улсын хувьд өргөн нэвтрүүлэгтэй холбоотой харилцаа 2019 оныг хүртэл Харилцаа холбооны тухай хуулиар буюу тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хүрээнд зохицуулагдаж ирсэн бөгөөд Өргөн нэвтрүүлгийн тухай хууль 2019 онд анх удаа батлагдаж гарснаар Монгол Улсад медиа салбарт үйлчилгээ эрхлэх эрх зүйн үндэс тодорхойлогдох анхны суурь тавигдсан. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар өргөн нэвтрүүлгийн салбарын онцлог зохицуулалт болох хэт төвлөрлийг 18 дугаар зүйлээр, эзэмшлийн мэдээлэл ирүүлэх, мэдээлэхтэй холбоотой харилцааг 19 дүгээр зүйлээр тус тус зохицуулсан. Гэхдээ Өргөн нэвтрүүлгийн тухай хууль агуулгын хувьд ерөнхий байдлаар батлагдсанаар зах зээлд шударга өрсөлдөх нөхцөлийг хэрхэн бүрдүүлэх, эзэмшлийн болон зах зээлийн хэт төвлөрлөөс хэрхэн сэргийлэх, ямар арга хэмжээг авч хэрэгжүүлэх зэрэг холбогдох харилцааг хуульд тодорхой зааж өгөөгүй, нарийвчилсан харилцааг хуулийн 18.2-т заасан журмаар зохицуулахаар хуульд тусгасан байдаг. Энэ нь хуулийн хэрэгжилтийг хангуулахад тодорхойгүй байдлыг бий болгохоос гадна журмаар зохицуулах харилцааг тодорхойлоход бэрхшээлийг дагуулж байгаа юм.

Харилцаа холбооны зохицуулах хорооноос Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дах хэсгийг үндэслэн "Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэх журам"-ыг 2021 оны 73 дугаар тогтоолоор баталж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлсэн боловч Зөвшөөрлийн зөвлөлийн 2025 оны 1 дугаар дүгнэлтийн хүрээнд хууль давсан, хуулиар зохицуулаагүй харилцааг журмаар дэлгэрүүлэн зохицуулсан гэдэг үндэслэлээр хүчингүй болгох нөхцөл бүрдсэн байдаг.

Эзэмшлийн мэдээлэл:

Харилцаа холбооны зохицуулах хороо өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчийн эзэмшлийн мэдээллийг жил бүрийн 12-р сарын 31-ний өдрийн байдлаар гаргуулан авч олон нийтэд нээлттэй мэдээлдэг бөгөөд тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн гаргасан хувьцааных нь тав ба түүнээс дээш хувийг эзэмшдэг хувьцаа эзэмшигч болон компанийн эрх бүхий албан тушаалтан өөрчлөгдсөн тохиолдолд өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч нь энэ тухай 30 хоногийн дотор тус хороонд бичгээр, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэх зохицуулалтай.

Харилцаа холбооны зохицуулах хорооноос өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн эзэмшлийн мэдээллийг жил бүрийн 12-р сарын 31-ний байдлаар гаргуулан авч, мэдээллийг шинэчилж, олон нийтэд нээлттэй мэдээлж байна. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшлийн 2025 оны мэдээлэлтэй тус Хорооны цахим хуудаснаас дэлгэрэнгүй байдлаар танилцах боломжтой. <https://www.crc.gov.mn/orgon-nevtruulgiin-televiz>

Хүснэгт 1. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийн төрөл, тоо (2025.12.31)

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийн төрөл	Үйлчилгээ эрхлэх байршлаар	
	УБ	Орон нутаг
Монголын үндэсний олон нийтийн радио телевиз	9	-
Өргөн нэвтрүүлгийн телевиз	18	38
Арилжааны телевиз	55	3
Төлбөртэй телевиз	20	-
Радио	30	34
Олон суваг дамжуулах үйлчилгээ	11	14
Радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэх	1	-
НИЙТ	233	

Хүснэгт 2. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн эрх зүйн статус

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчид нийт тоо	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх зүйн статус								
	НЭЗХЭ (Олон нийтийн)	УТҮГ	ТӨҮГ	ХХК	ТББ	ХМБ*	ШБ**	Иргэн	
233	9	1	1	181	15	2	1	1	

Тайлбар: ХМБ-*Хэвлэл мэдээллийн байгууллага*, ШБ-*Шашны байгууллага*

Өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөлтэй 233 эзэмшигчийн дотроос олон нийтийн статустай 9 радио, телевиз (Монголын үндэсний олон нийтийн телевиз, радиогийн үндсэн 2 суваг болон түүний харьяа бусад сувгууд) болон улсын төсөвт болон төрийн өмчит үйлдвэрийн газрын 2 үйлчилгээ эрхлэгчийг хасахад, нийт 222 үйлчилгээ эрхлэгч хувийн өмчийн хэлбэртэй, хуулийн этгээдийн нэр дээр бүртгэгдсэн байна. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хуулийн этгээдийн хэлбэрийг авч үзэхэд 90,5% нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн нэр дээр байна.

1. Өргөн нэвтрүүлгийн эзэмшлийн байдал (Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн бүтэц, хуулийн этгээдийн ангилал, эцсийн өмчлөгчийн төвлөрлийн жишээ)

ӨНТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.1-д заасны дагуу өргөн нэвтрүүлгийг хараат бус, нээлттэй, ёс зүйтэй байдлыг хангуулах зорилгоор өргөн нэвтрүүлгийн эзэмшлийг ил тод, нээлттэй байлгахаар дараах байдлаар зохицуулсан. Тухайлбал:

- Өргөн нэвтрүүлгийг хараат бус, нээлттэй, ёс зүйтэй байлгах зорилгоор өргөн нэвтрүүлгийн эзэмшлийг ил тод байлгана. (ӨНТХ-ийн 19.1);
- Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь Зохицуулах хороонд жил бүрийн 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор тусгай зөвшөөрлийн эзэмшлийн талаарх мэдээллийг хүргүүлнэ. (ӨНТХ-ийн 19.2);
- Тусгай зөвшөөрлийн эзэмшлийн талаарх мэдээллийг Зохицуулах хороо олон нийтэд мэдээлнэ. (ӨНТХ-ийн 19.5);
- Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийн эзэмшлийн мэдээллийг Зохицуулах хороонд гаргаж өгөөгүй, нуусан тохиолдолд

тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэл арга хэмжээ авна. (ӨНТХ-ийн 19.6) гэж тус тус заасан байдаг.

ХХЗХ нь өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшлийг олон нийтэд ил тод мэдээлэх, хэт төвлөрөл бий болохоос сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй. (ӨНТХ-ийн 30.1.2)

ХХЗХ-оос хуульд заасан дээрх бүрэн эрх, чиг үүргийг хэрэгжүүлж, тус хорооноос тусгай зөвшөөрөлтэй өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдээс эзэмшлийн мэдээллийг жил бүрийн 12 дугаар сарын 31-ний байдлаар хүлээн авч, нэгтгэн 1-р улиралд багтаан Хорооны цахим хуудсаар 2021 оноос жил бүр олон нийтэд ил тод мэдээлж байна. Энэхүү мэдээлэлтэй ХХЗХ-ны цахим хуудасны <https://shorturl.at/gAA8I> холбоосоор нэвтэрч танилцах боломжтой.

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн тоо 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 233 байсан бөгөөд эзэмшлийн мэдээллийг тусгай зөвшөөрөл бүрээр зөвшөөрлийн төрөл тус бүрээр гаргасан.

Тиймээс одоогийн байдлаар өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь эрх зүйн статусаар хязгаарлагдмал хариуцлагатай компани, хувьцаат компани, төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, улсын төсөвт үйлдвэрийн газар, нийтийн эрх зүйн хуулийн этгээд, шашны байгууллага болон иргэн гэсэн 9 төрөлд ангилагдаж байна. Хүснэгт 3

Хүснэгт 3. Тусгай зөвшөөрлийн эзэмшлийн эрх зүйн статус

№	Эрх зүйн статус	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тоо	Тусгай зөвшөөрлийн тоо
1	Хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК)	156	196
2	Төрийн бус байгууллага (ТББ)	16	19
3	Хэвлэл мэдээллийн байгууллага (ХМБ)	3	3
4	Хувьцаат компани (ХК)	1	1
5	Төрийн өмчит үйлдвэрийн газар (ТӨҮГ)	1	2
6	Улсын төсөвт үйлдвэрийн газар (УТҮГ)	1	1
7	Иргэн	1	1
8	Нийтийн эрх зүйн хуулийн этгээд	1	9
9	Шашны байгууллага	1	1
	Нийт	181	233

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний нэг тусгай зөвшөөрөлтэй 158 зөвшөөрөл эзэмшигч байгаа бол 2 буюу түүнээс дээш тусгай зөвшөөрөлтэй 23 зөвшөөрөл эзэмшигч байна. Нэг хуулийн этгээд дээр хоёр буюу түүнээс дээш тусгай зөвшөөрөл эзэмшиж буй 23 этгээдийн 1 нь ТББ, 1 ТӨҮГ, 1 Монголын үндэсний олон нийтийн

радио, телевиз (МҮОНРТ) байгаа бол бусад 20 нь хувийн хэвшлийн ашгийн төлөө үйл ажиллагаатай компани байна. Эдгээрийн эзэмшиж буй тусгай зөвшөөрлийг зөвшөөрлийн төрлөөр нь гарган авч үзлээ. Хүснэгт 4

Хүснэгт 4. Хоёр буюу түүнээс дээш тусгай зөвшөөрөл эзэмшиж буй зөвшөөрөл эзэмшигчид, зөвшөөрлийн төрлөөр

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигч	Нийт тусгай зөвшөөрлийн тоо	Телевизийн зөвшөөрлийн тоо, төрөл	Радиогийн зөвшөөрлийн тоо, төрөл
1	Монвсат нэтворк ХХК	6	1 (арилжааны ТВ) 5 (төлбөртэй ТВ)	-
2	Номадиа нэтворкс ХХК	5	5 (төлбөртэй ТВ)	-
3	Премьер спортс нэтворк ХХК	5	5 (арилжааны ТВ)	-
4	Эх элгэн нутаг ХХК	5	-	5 (арилжааны радио-орон нутаг)
5	Дархан мэдээлэл төв ХХК	4	1 (өргөн нэвтрүүлгийн ТВ-орон нутаг)	3 (арилжааны радио-орон нутаг)
6	Маст технологи ХХК	4	1 (арилжааны ТВ) 3 (төлбөртэй ТВ)	
7	Монгол монголчуудын сонсох ном НҮТББ	4	-	4 (арилжааны радио-орон нутаг)
8	Гэгээн далай ХХК	3	1 (өргөн нэвтрүүлгийн ТВ) 2 (арилжааны ТВ)	-
9	Контент дистрибьюшн ХХК	3	3 (төлбөртэй ТВ)	-
10	Медиа холдинг ХХК	3	1 (өргөн нэвтрүүлгийн ТВ) 1 (арилжааны ТВ)	1 (арилжааны радио)
11	Малчин удмын хийморь ХХК	2	1 (өргөн нэвтрүүлгийн ТВ) 1 (арилжааны ТВ)	-
12	Монгол контент ХХК	2	1 (арилжааны ТВ) 1 (төлбөртэй ТВ)	-
13	Монгол телевиз ХХК	2	1 (өргөн нэвтрүүлгийн ТВ) 1 (арилжааны ТВ)	-
14	Скайтел ХХК	2	2 (төлбөртэй ТВ)	-
15	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	2	1 (өргөн нэвтрүүлгийн ТВ-орон нутаг)	1 (арилжааны радио-орон нутаг)
16	Дадишуар гоёл ХХК	2	1 (өргөн нэвтрүүлгийн ТВ-орон нутаг)	1 (арилжааны радио-орон нутаг)
17	Ар Би Эм Ти ХХК	2	1 (өргөн нэвтрүүлгийн ТВ-орон нутаг)	1 (арилжааны радио-орон нутаг)
18	Түвдэнгийн Бор Интернэшнл ХХК	2	1 (өргөн нэвтрүүлгийн ТВ-орон нутаг)	1 (арилжааны радио-орон нутаг)
19	Ди медиа агентлаг ХХК	2	1 (өргөн нэвтрүүлгийн ТВ-орон нутаг)	1 (арилжааны радио-орон нутаг)
20	Эн Ти Ви БROADCASTING ХХК	2	1 (өргөн нэвтрүүлгийн ТВ) 1 (арилжааны ТВ)	-
21	Буян налайх ХХК	2	1 (өргөн нэвтрүүлгийн ТВ-орон нутаг)	1 (арилжааны радио-орон нутаг)
22	Одтой цэг ХХК	2	-	2 (арилжааны радио-орон нутаг)
23	МҮОНРТ	9	5 (олон нийтийн)	4 (олон нийтийн)

Нийт	75		
------	----	--	--

Эдгээр 23 зөвшөөрөл эзэмшигчид нийт 75 тусгай зөвшөөрөл эзэмшиж байна.

МҮОНРТ нь Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.5-д заасны дагуу “олон нийтийн радио, телевизийн үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрлийн хүрээнд 5 телевиз, 4 радиотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь Орхон-Уул аймагт үйл ажиллагаа эрхлэх өргөн нэвтрүүлгийн телевизийн 1, арилжааны радиогийн 1 зөвшөөрөл эзэмшиж байна. Эх элгэн нутаг ХХК, Дархан мэдээлэл төв ХХК, Монгол монголчуудын сонсох ном НҮТББ, Одтой цэг ХХК гэсэн зөвшөөрөл эзэмшигчдийн хувьд орон нутагт арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх 2-оос дээш тусгай зөвшөөрөлтэй байгаа нь радиогийн үйлчилгээний хувьд үйлчилгээ эрхлэх хүрээг нэмэгдүүлэх боломжгүй, радио давтамж ашиглах тусгай зөвшөөрлийг үйлчилгээний байршил тус бүрээр сонгон шалгаруулалтаар авах шаардлагатай байдагтай холбоотойгоор 2-5 тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа болно. Харин телевизийн үйлчилгээний хувьд ижил төрлийн 2-оос дээш тусгай зөвшөөрөлтэй байгаа нь телевизүүд нь хөтөлбөрийн хувьд ялгаатай буюу өөрөөр хэлбэл зөвшөөрөл эзэмшигч нь хэд хэдэн телевизийн үйлчилгээ эрхлэх зорилгоор авсан зөвшөөрлүүд юм. Хувийн хэвшлийн компаниудаас хамгийн олон буюу арилжааны болон төлбөртэй телевизийн нийт 6 зөвшөөрөлтэй Монвсат нэтворк ХХК, төлбөртэй телевизийн 5 зөвшөөрөлтэй Номадиа нэтворкс ХХК, арилжааны телевизийн 5 зөвшөөрөлтэй Премьер спортс нэтворк ХХК зэрэг байна. Орон нутгийн Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, Дадишуар гоёл ХХК, Ар Би Эм Ти ХХК, Түвдэнгийн Бор Интернэшнл ХХК, Ди медиа агентлаг ХХК, Буян налайх ХХК гэсэн зөвшөөрөл эзэмшигчдийн хувьд өргөн нэвтрүүлгийн болон арилжааны радиогийн тус бүр нэг тусгай зөвшөөрөл эзэмшиж байна.

Харин тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хувьцаа эзэмшигч, эцсийн эзэмшигч, эцсийн өмчлөгчөөр нь авч үзвэл арай өөр дүр харагдаж байна. Эцсийн эзэмшигч, өмчлөгчөөр нь авч үзэхэд 2 буюу түүнээс дээш тусгай зөвшөөрөл эзэмшиж буй 8 зөвшөөрөл эзэмшигч байна. Эдгээрийн хэлхээ холбоог доор нэг бүрчлэн авч үзлээ. Хүснэгт 5

Хүснэгт 5. Эцсийн өмчлөгч дээр 100 хувь эзэмшилтэй хоёр буюу түүнээс дээш тусгай зөвшөөрөл хоорондын хамаарал

Эзэмшлийн байдал, эцсийн өмчлөгч	Тусгай зөвшөөрлийн тоо	Тусгай зөвшөөрөл эзэмшигч	Үйлчилгээний нэр	Тусгай зөвшөөрлийн төрөл	Зах зээлд эзлэх хувь
----------------------------------	------------------------	---------------------------	------------------	--------------------------	----------------------

1 иргэн – 100% С.Болдхэт	2	Супер вижн медиа групп ХХК	SBN	Өргөн нэвтрүүлгийн ТВ	1.6%
		Эм Ви Эс ХХК	Monplus	Арилжааны ТВ	
1 иргэн – 100% Д.Баясгалан	9	Ийгл Бродкастинг ХХК	Ийгл ньюс	Өргөн нэвтрүүлгийн ТВ	16.6%
		Медиа боловсрол суваг ХХК	Боловсрол суваг	Өргөн нэвтрүүлгийн ТВ	
		Мөрөөдлийн суваг ТББ	Dreambox	Арилжааны ТВ	
		Шууд Ти Ви ХХК	Асар шоп	Арилжааны ТВ	
		Эйшн бокс ХХК	AsianBox	Арилжааны ТВ	
		Мөүвибокс ХХК	MovieBox	Арилжааны ТВ	
		Мюзик бокс ХХК	Хөг-жим	Арилжааны ТВ	
		Мөүви бокс плас ХХК	MovieBox Plus	Төлбөртэй ТВ	73.4%
		Монгол комикс ХХК	ФМ 91.1	Арилжааны радио	-
2 иргэн-100% Э.Долгион Ц.Эрдэнэбаяр	2	Лариско медиа групп ХХК	CNBC Mongolia	Арилжааны ТВ	0.1%
		Лейди чаннел ХХК	MNC	Арилжааны ТВ	
1 компани - 100% Мобиком корпораци ХХК	3	Монгол контент ХХК	Gogo TV	Арилжааны ТВ	Үйл ажиллагаа туршилтаар явуулж эхэлсэн
		Монгол контент ХХК	Voo Max	Төлбөртэй ТВ	5.2%
		Мобинет ХХК	Voo	ОСДҮ	8.9%


Тусгай зөвшөөрөл нь өөр өөр компани дээр зөвшөөрөлтэй хэдий ч эцсийн өмчлөгч нь нэг иргэний 100 хувийн эзэмшилтэй өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрлүүд гэвэл иргэн С.Болдхэт телевизийн 2 тусгай зөвшөөрөлтэй, иргэн Д.Баясгалан телевизийн 8, радиогийн 1 тусгай зөвшөөрлийн эцсийн өмчлөгч байна. Харин иргэн Э.Долгион, Ц.Эрдэнэбаяр нар нь 2 арилжааны телевизийн эцсийн өмчлөгч байна. Мобиком корпораци ХХК нь охин компаниудаараа дамжуулан арилжааны, төлбөртэй телевиз болон олон суваг дамжуулах үйлчилгээний нийт 3 тусгай зөвшөөрлийг тус тус эзэмшиж байна.

Өргөн нэвтрүүлгийн тухай зөвшөөрлийг эзэмшлийн байдлыг нэг этгээд, түүний хамаарал бүхий этгээдийн эзэмшиж буй зөвшөөрлүүдийг гаргаж, төвлөрлөөр нь тухайн эзэмшлийн зах зээлд эзлэх хувь хэмжээг гарган авч үзлээ. Зах зээлийн байдлыг өргөн нэвтрүүлгийн болон арилжааны телевизийн зах зээл, төлбөртэй телевизийн зах зээл, радиогийн зах зээл болон олон суваг дамжуулах үйлчилгээний зах зээл гэж ангилан, энэхүү эзэмшлийн үнэлгээ дүгнэлт тус бүрд гаргалаа.

Харин өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлийн дэлгэрэнгүй мэдээллийг Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30.1.3-т заасны дагуу Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний нөхцөл байдалд хийсэн үнэлгээ, дүгнэлт боловсруулж, 2026 оны II улиралд Харилцаа холбооны зохицуулах хорооны цахим хуудсаар нийтэд мэдээлсэн болно.

Өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрлийг охин, хараат компаниудаараа дамжуулан хэд хэдэн иргэн, хуулийн этгээд эзэмшиж байгаа тохиолдлууд цөөнгүй байдаг.

Зураг 1. UBS, Глобал телевизийн хоорондын эзэмшлийн хамаарал




Тухайлбал: Зураг 1-т Улаанбаатар телевиз ХХК нь UBS телевизийн тусгай зөвшөөрөл эзэмшигч бол арилжааны Айст глобал телевизийн тусгай зөвшөөрөл эзэмшигч Форчун глобал ХХК-ийн 75.5%-ийг эзэмшдэг байна. болон. Харин Буряад ТВ АББ нь Форчун глобал ХХК болон Манай аялгуу Эф Эм Ар ХХК-ийн 24.5%-ийн тус тус эзэмшиж байна. Өргөн нэвтрүүлгийн UBS телевиз болон арилжааны Айст глобал телевиз нь телевизийн зах зээлийн 3.3%-ийг эзэлж байгаа бол VIP ФМ 90.5 нь радиогийн зах зээлийн 0.9%-ийг бүрдүүлж байна.

Зураг 2-т олон суваг дамжуулах үйлчилгээний Юнивишн, Ддэш болон спортын төрөлжсөн хөтөлбөртэй арилжааны PSN 1, PSN 2, PSN 3, PSN 4, PSN 5 телевиз хоорондын эзэмшлийн холбоо хамаарлыг үзүүллээ. Юнител ХХК-ийн охин компани болох Юнивишн ХХК нь олон суваг дамжуулах АйПиТВ үйлчилгээний Юнивишн үйлчилгээг үзүүлж байна. Хиймэл дагуулаар олон суваг дамжуулах үйлчилгээ үзүүлэгч ДДэш ТВ үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшигч ДДэш ТВ ХХК-ийн 51%-ийг иргэн Ц.Цэрэнпунцаг эзэмшиж байгаа бол Юнител ХХК-ийн охин


компани болох Орбитнет ХХК нь 49%-ийг эзэмшиж байна. Үүнээс харахад Юнивишн, Ддэш үйлчилгээнүүд эзэмшлийн хувьд хоорондоо хамааралтай байгаа нь харагдаж байна. Спортын PSN телевизүүдийн Премьер спорт нэтворк ХХК-ийн 30%-ийг иргэн Ц.Пүрэвжаргал, 70%-ийг Юнител ХХК-ийн охин компани болох Контент дистрибьюшн ХХК эзэмшиж байна. Юнител ХХК-ийн 100%-ийн хувьцаа эзэмшигч гадаадын хөрөнгө оруулалттай Nomadcom Pte.,Ltd байгаа бөгөөд уг компаний хувьцааны 43.9%-ийг иргэн Ж.Оджаргал эзэмшиж байна.

Зураг 2. Юнивишн, Ддиш олон суваг дамжуулах үйлчилгээ болон PSN спортын төрөлжсөн хөтөлбөртэй арилжааны телевиз хоорондын эзэмшлийн хамаарал



PSN 1, PSN 2, PSN 3, PSN 4, PSN 5 телевиз нь өргөн болон арилжааны телевизийн зах зээлийн 18.8%, UniLive нь төлбөртэй телевизийн 0.9% бүрдүүлж байгаа бол ДДэш бол Юнивишн нь олон сувгийн зах зээлийн 80.7%-ийг бүрдүүлж байна.

Зураг 3. MongolTV, TenGer телевиз болон олон суваг дамжуулах Ori үйлчилгээ хоорондын эзэмшлийн хамаарал




Зураг 3-т өргөн нэвтрүүлгийн Mongol TV, TenGer телевизүүд, арилжааны MongolTV +1 телевиз болон Ori олон суваг дамжуулах үйлчилгээний эзэмшлийн хоорондын холбоо хамаарлыг гарган үзүүлээ. Тэнгэрлиг медиа групп ХК нь Монгол телевиз ХХК-ийн 20%-ийг, Промедиа нетворк ХХК-ийн 80%-ийг эзэмшиж байгаа бөгөөд Монгол телевиз ХХК-ийн 80%-ийг эзэмшигч Л.Чинбат нь Тэнгэрлиг медиа групп ХК-ийн хувьцааны 23.3%-ийг мөн эзэмшдэг байна. Эзэмшлийн мэдээлэлтэй ХХЗХ-ны цахим хуудасны <https://shorturl.at/gAA8l> холбоосоор нэвтэрч танилцана уу. Үүнээс харахад иргэн Л.Чинбат нь олон суваг дамжуулах үйлчилгээний Ori, өргөн нэвтрүүлгийн Монгол ТВ, TenGer телевизүүд, арилжааны Монгол ТВ+1 телевизийн эзэмшигчдийн нэг гэдэг нь харагдаж байна.

Зураг 4-т үзүүлсэн өргөн нэвтрүүлгийн NTV телевиз, арилжааны N movies, N sports телевизүүд, төлбөртэй SkyLive, MN+ телевизүүд, арилжааны Эх дэлхий ФМ 107.0 радио болон Скаймедиа олон суваг дамжуулах үйлчилгээний тусгай зөвшөөрлийг эзэмшлээр нь хоорондын харилцан хамаарлыг авч үзлээ. Эдгээр үйлчилгээг Шунхлай холдинг ХХК нь өөрийн 100%-ийн эзэмшлийн охин компаниудаараа дамжуулан дээрх үйлчилгээнүүдийг үзүүлж байна. Энэхүү NTV, N movies, N sports телевиз нь өргөн болон арилжааны телевизийн зах зээлийн 7.6%-ийг, SkyLive, MN+ сувгууд нь төлбөртэй телевизийн зах зээлийн 2.3%, Эх дэлхий ФМ

107.0 нь радиогийн зах зээлийн 0.2%, Скаймедиа нь олон сувгийн зах зээлийн 5.6%-ийг тус тус бүрдүүлж байна.

Зураг 4. NTV, Скаймедиа хоорондын эзэмшлийн хамаарал



2. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдийн талаарх мэдээлэл, судалгаа (2025 оны эзэмшлийн мэдээллийн хүрээнд гаргасан судалгаа)

2.1. Өргөн нэвтрүүлэг дэх гадаад эзэмшлийн зохицуулалт, нөхцөл байдал:

Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-ын 3.2.2.2-т "Гадаадын аль нэг орноос хийгдэх хөрөнгө оруулалтын хувь, хэмжээг гадаадын нийт хөрөнгө оруулалтын гуравны нэгээс хэтрэхгүй байлгах бодлого баримтална. Гадаадын төрийн өмчит компанийн хөрөнгө оруулалтыг хязгаарлаж, стратегийн ач холбогдолтой салбарт хөрш орон, өндөр хөгжилтэй бусад орноос оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг тэнцвэртэй байлгах бодлого баримтална." гэж, 3.6.1.4-т "Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалттай хэвлэл мэдээллийн хэрэгсэл үндэсний аюулгүй байдалд харшилсан үйл ажиллагаа явуулбал үйл ажиллагаа явуулах эрхийг нь хязгаарлаж болно. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшил, харьяалал нь ил тод байх бөгөөд үйл ажиллагаа нь бодитой, тэнцвэртэй, хариуцлагатай байна.

Мэдээллийн хэрэгслээр үндэсний үнэт зүйлийг түлхүү нийтлэх, сурталчлахыг дэмжиж, гадны шашин, соёл, төрийн бодлогыг сурталчилсан агуулгатай мэдээллийг зохистой түвшинд хязгаарлана.” гэж тус тус заасан.

Хэвлэл мэдээллийн салбар дахь гадаад эзэмшил нь үндэсний аюулгүй байдал, мэдээллийн тусгаар тогтнолд нөлөөлөх эрсдэлтэй гэж үздэг тул зарим улс энэ чиглэлээр гадаадын хөрөнгө оруулалт, эзэмшилд тодорхой хязгаарлалт, зохицуулалт хэрэгжүүлдэг байна.

Монгол Улсад гадаадын төрийн өмчит хуулийн этгээдээс оруулах хөрөнгө оруулалтыг стратегийн ач холбогдолтой салбар (гурван салбарын нэг нь хэвлэл, мэдээлэл, харилцаа холбооны салбар)-т Монгол Улсын хуулийн этгээдийн нийт хувьцааны гуравны нэг буюу 33 хувиас хэтрүүлсэн бол зөвшөөрөл авах, хэтрүүлээгүй бол зөвшөөрөл авахгүй байх Хөрөнгө оруулалтын тухай хуулийн зохицуулалттай. Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээдэд олгохоор заасан (7.2) бөгөөд харин гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд (7.3.3) болон төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл удирдлагын баг /захирал, дэд захирал, менежер/-ийн 30-аас дээш хувь нь гадаадын иргэн эзэлж байгаа аж ахуйн нэгж байгууллагад (7.3.5) тусгай зөвшөөрөл олгохыг хориглосон.

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшлийн мэдээлэлд хяналт шинжилгээ хийхэд арилжааны 9 телевиз, төлбөртэй 2 телевиз, арилжааны 2 радио, 3 олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн эзэмшил (шууд болон толгой компани)-д Монгол Улсад бүртгэлтэй гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд, гадаадын хөрөнгө оруулагч этгээд болон гадаадын хэвлэл мэдээллийн байгууллагын хувь эзэмшил бүртгэгдсэн байна. (Хүснэгт 6, 7, 8). Монгол Улсад бүртгэлтэй гадаадын хөрөнгө оруулалттай ¹ хуулийн этгээд тусгай зөвшөөрөл эзэмшиж байна.

Үүнд: Глобал ТВ, NTN, GoGo TV, Блүүмбэрг суваг, Premier sport 1,2,3,4,5 арилжааны телевиз, Voo max, Юнилайв 88 төлбөртэй телевизийн эзэмшилд тус тус МУ-д бүртгэлтэй гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд (ГХО), гадаад улсын иргэн, гадаад улсад бүртгэлтэй хуулийн этгээд болон гадаад улсын хэвлэл мэдээллийн байгууллага бүртгэлтэй байгаа бол радиогийн хувьд Хэмнэл радио FM-91.7, VIP радио FM-90.5 радиогийн үйлчилгээ эрхлэгч хуулийн этгээдийн эзэмшлийн бүтцэд ((шууд болон толгой компанийн түвшинд)-)шилд тус тус гадаад улсын иргэн, гадаад улсын хэвлэл мэдээллийн байгууллагын эзэмшил бүртгэгдсэн байна. н байгууллага бүртгэлтэй байна. Хүснэгт 6,7-т харуулав.

Хүснэгт 6. Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн эзэмшилд гадаадын хөрөнгө оруулалт бүртгэгдсэн үйлчилгээ эрхлэгчдийн жагсаалт.

¹ Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1-р зүйлд “Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийг дагаж мөрдөхөөс өмнө (2020 оны 7-р сарын 1-ээс өмнө) улсын бүртгэлд бүртгүүлж, зохих журмын дагуу үйл ажиллагаа явуулж байсан өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх эрх хүчин төгөлдөр байна.” гэж заасныг баримтлан Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэх талаар тухайн хуулийн этгээдэд ямар нэг шаардлага тавих үндэслэлгүй гэж ХХЗХ-с үзсэн.

ДД	Телевизийн нэр	Хуулийн этгээдийн эзэмшил	Харьяалал
1	Глобал ТВ	Форчун глобал ХХК - Буряад ТВ (Автономная некоммерческая организация, ЭЛ № ФС 77 – 80158 - Роскомнадзор) 24.5%	ОХУ
2	NTN	Эн Ти Эн Эйч Ди Медиа Групп ХХК - Хүрэл-Интернэшнл ГХО ХХК (30%) – иргэн Hurilesha, Х.Амарбат	БНХАУ
3	GoGo TV Voo max	Монгол контент ХХК - Мобиком корпораци ГХО ХХК	Япон улс
4	Блүүмбэрг суваг	Нэйшнл ньюс корпорэйшн ХХК – Худалдаа хөгжлийн банк ХК нээлттэй - Globull Investment and Development PTE.LTD (60.8%)	Бүгд Найрамдах Сингапур улс
5	Premier sport 1,2,3,4,5	Премьер спортс нэтворк ХХК - Контент дистрибьюшн ХХК – Юнител ГХО ХХК	Бүгд Найрамдах Сингапур улс
6	Юнилайв 88	Контент дистрибьюшн ХХК – Юнител ГХО ХХК	Бүгд Найрамдах Сингапур улс

Хүснэгт 7. Радиоогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн эзэмшилд гадаадын хөрөнгө оруулалт бүртгэгдсэн үйлчилгээ эрхлэгчдийн жагсаалт.

ДД	Радиоогийн нэр	Хуулийн этгээдийн эзэмшил	Харьяалал
1	Хэмнэл радио FM-91.7	Хэмнэлт долгион медиа групп ХХК - Дансол Гэйтвэй ХХК (хувьцаа эзэмшигч иргэн Pagarigan Angelina 1/6)	Бүгд Найрамдах Филиппин Улс
2	VIP радио FM-90.5	Манай аялгуу Эф Эм Ар ХХК - Буряад ТВ (Автономная некоммерческая организация, ЭЛ № ФС 77 – 80158 - Роскомнадзор) 24.5%	ОХУ

Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн тухайд Мобинет ХХК, Юнивишн ХХК-ийн 100% эзэмшигч нь тус тус Монгол улсад бүртгэлтэй гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдүүд байгаа бол Сансар дижитал ХХК-ийн 100% хувьцаа эзэмшигч Сансар кабель ХХК-ийн эзэмшилд гадаад улсын 3 иргэн бүртгэлтэй байна. Шинэ сансар кабель гадаад улсын хөрөнгө оруулалттай ХХК-ийн 32%-ийн хувьцааг гадаад улсын хуулийн этгээд эзэмшиж байна. Мөн Шинэ сансар кабель гадаад улсын хөрөнгө оруулалттай ХХК болон Сансар дижитал ХХК-ийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий албан тушаалтан гадаад улсын иргэд байна. Дэлгэрэнгүйг Хүснэгт 8-д харуулав.

Хүснэгт 8. Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн эзэмшилд гадаадын хөрөнгө оруулалт (ГХО) бүртгэгдсэн үйлчилгээ эрхлэгчдийн жагсаалт.

ДД	Олон суваг дамжуулах үйлчилгээний нэр	Хуулийн этгээдийн эзэмшил	Харьяалал
1	Beyond Media	Шинэ сансар кабель ГХО ХХК - ӨМӨЗО-ны Лунбан сүлжээний технологи ХК 32%, Сансар кабель ХХК (Zhao Baoping, Xiang Shengli, Lin Dong 3/4) Гүйцэтгэх захирал – Gao Chuanjin	БНХАУ
2	Sansar digital	Сансар Дижитал ХХК - Сансар кабель ХХК (Zhao Baoping, Xiang Shengli, Lin Dong 3/4). Гүйцэтгэх захирал – Tala	БНХАУ
3	Voo	Мобинет ХХК - Мобиком корпораци ГХО ХХК	Япон улс
4	Univision	Юнивишн ХХК – Юнител ГХО ХХК	Бүгд Найрамдах Сингапур улс

Өргөн нэвтрүүлэг дэх гадаад улсын хөрөнгө оруулалтын судалгааг нэгтгэн дүгнэхэд дараах төрлийн тохиолдлууд байгааг судалж гаргаж ирсэн болно.

1. Тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн эзэмшилд гадаад улсын өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд хувь эзэмшилтэй байгаа тохиолдол:

- ✓ Глобал ТВ арилжааны телевиз, VIP радио FM-90.5 арилжааны радиогийн тусгай зөвшөөрөлтэй Форчун глобал ХХК-ийн 24.5%-ийн хувьцааг ОХУ-ын хэвлэл мэдээллийн байгууллага болох Буряад ТВ (Автономная некоммерческая организация, ЭЛ № ФС 77 – 80158 - Роскомнадзор) эзэмшиж байна.

2. Тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн толгой компани гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд байгаа болон толгой компанийн хувьцааг гадаад улсын иргэн эзэмшиж байгаа тохиолдол:

- ✓ NTN арилжааны телевизийн тусгай зөвшөөрөлтэй Эн Ти Эн Эйч Ди Медиа Групп ХХК-ийн 30%-ийн хувьцааг Хүрэл-Интернэшнл гадаадын хөрөнгө оруулалттай ХХК (БНХАУ) эзэмшиж байна.

- ✓ Хэмнэл радио FM-91.7 арилжааны радиогийн тусгай зөвшөөрөлтэй Хэмнэлт долгион медиа групп ХХК-ийн 100% хувьцааг Дансол Гэйтвэй ХХК эзэмшиж байгаа ба уг компанийн 1 хувьцаа эзэмшигч БНФилиппин улсын иргэн Pagarigan Angelina байна.

- ✓ GoGo TV арилжааны телевиз, Voo тах төлбөртэй телевизийн тусгай зөвшөөрөлтэй Монгол контент ХХК-ийн 100% хувьцааг Мобиком корпораци гадаадын хөрөнгө оруулалттай ХХК (Япон улс) эзэмшиж байна.

- ✓ Юнилайв 88 төлбөртэй телевизийн тусгай зөвшөөрөлтэй Контент дистрибьюшн ХХК-ийн 100% хувьцааг Юнител гадаадын хөрөнгө оруулалттай ХХК (БНСингапур улс) эзэмшиж байна.
 - ✓ Блүүмбэрг арилжааны телевизийн тусгай зөвшөөрөлтэй Нэйшнл ньос корпорэйшн ХХК-ийн 100% хувьцааг Худалдаа хөгжлийн банк нээлттэй ХК эзэмшиж байгаа ба уг компанийн 60.8%-ийн хувьцааг Глобулл Инвестмент энд Девелопмент хязгаарлагдмал хариуцлагатай компани (БНСингапур улс) эзэмшиж байна.
 - ✓ Premier sport 1,2,3,4,5 арилжааны телевизийн тусгай зөвшөөрөлтэй Премьер спортс нэтворк ХХК-ийн 70% хувьцааг эзэмшигч Контент дистрибьюшн ХХК нь Юнител гадаадын хөрөнгө оруулалттай ХХК-ийн 100% хөрөнгө оруулалттай (БНСингапур улс) байна.
3. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд нь гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд байгаа тохиолдол:
- ✓ Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй Шинэ сансар кабель ХХК нь гадаадын хөрөнгө оруулалттай бөгөөд хувьцааны 32%-ийг БНХАУ-ын ӨМӨЗО-ны Лунбан сүлжээний технологи ХК, үлдсэн 68%-ийн хувьцааг Сансар кабель ХХК тус тус эзэмшиж байна. Түүнчлэн Сансар кабель ХХК-ийн хувьцаа эзэмшигч 4 хүний нэг нь Монгол Улсын иргэн, бусад гурав нь БНХАУ-ын иргэд Zhao Baoping, Xiang Shengli, Lin Dong нар байна.
4. Тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөл, удирдлагын багт гадаадын иргэд байгаа тохиолдол:
- ✓ Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй Шинэ сансар кабель гадаадын хөрөнгө оруулалттай ХХК-ийн гүйцэтгэх захирлаар БНХАУ-ын иргэн Gao Chuanjin бүртгэлтэй байна.
 - ✓ Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй Сансар дижитал ХХК-ийн гүйцэтгэх захирлаар БНХАУ-ын иргэн Tala бүртгэлтэй байна.

Гадаад улсын эзэмшил бүртгэгдсэн хуулийн этгээдийн тоон мэдээллээс харахад өргөн нэвтрүүлгийн салбарт өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх 17 тусгай зөвшөөрөлтэй (телевиз 11, радио 2, ОСДҮ 4) 11 хуулийн этгээдэд нийт 5 улсын хөрөнгө оруулалт бүртгэлтэй байна. Тоон мэдээллийг Хүснэгт 9-р харуулав.

Хүснэгт-9. Гадаад улсын эзэмшил бүртгэгдсэн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоон мэдээлэл.

Улс	Хуулийн этгээдийн тоо	Тусгай зөвшөөрлийн тоо	Үйлчилгээний төрөл
ОХУ	2	2	Тв-1, радио-1
БНХАУ	3	3	Тв-1, ОСДҮ-2

Япон улс	2	3	Тв-2, ОСДҮ-1
Бүгд Найрамдах Сингапур улс	3	8	Тв-7, ОСДҮ-1
Бүгд Найрамдах Филиппин Улс	1	1	Радио-1

2.2. Өргөн нэвтрүүлэг дэх давхар эзэмшил, төвлөрлийн зохицуулалт, өнөөгийн нөхцөл байдал:

Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 186 дугаар тогтоолоор “сүлжээг үр ашигтай, тэгш эрхтэйгээр ашиглуулах, үйлчилгээний салбарт өрсөлдөөн бий болгох нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор аж ахуйн нэгжид олгох тусгай зөвшөөрлийг сүлжээ болон үйлчилгээний чиглэлээр нэг аж ахуйн нэгжид давхардуулан олгохгүй байх” чиглэл баримталж ажиллахыг Харилцаа, холбооны зохицуулах хороонд үүрэг болгосон.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.3-т “радио, телевизийн газрын тоон сүлжээний үйлчилгээ болон олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг радио, телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй давхардуулан олгохгүй, эзэмшил нь тусдаа байх” зарчмыг Харилцаа холбооны зохицуулах хороо тусгай зөвшөөрөл олгохдоо баримталж ажиллахаар зохицуулсан байна.

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн эзэмшлийн мэдээлэл, эцсийн өмчлөгчийн хэлхээ холбоог судалж давхар эзэмшлийн өнөөгийн нөхцөл байдлын судалгааг гаргалаа. Үүнд:

1. Олон суваг дамжуулах үйлчилгээ (ОСДҮ) эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд болон телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдүүд нэг толгой компанид хамаарч, нэг эцсийн өмчлөгчтэй байгаа тохиолдол: Зураг 5,6,7

Зураг-5.

1. ОСДҮ ба Өргөн нэвтрүүлгийн ТВ:

Skymedia: Скаймедиа корпораци ХХК - Скайтел ХХК
NTV, N Movies : Эн Ти Ви Бродкастинг ХХК - Медиа групп ХХК
NTV sport: Монзах ХХК - Медиа групп ХХК

ORI media: Оримедиа ХХК
Монгол ТВ:

Шунхлай холдинг ХХК

Монгол телевиз ХХК

Зураг-6.

2. ОСДҮ ба Арилжааны ТВ:

Premier sport 1,2,3,4,5: Премьер спортс нэтворк ХХК - Контент дистрибушн ХХК
Univision: Юнивишн ХХК


GoGo TV: Монгол контент ХХК
Voo: Мобинет ХХК

Юнител ХХК

Мобиком Корпораци ХХК

Зураг-7.

3. ОСДҮ ба Төлбөртэй ТВ:




Тодруулга: Номадиа нэтворк ХХК-ийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий албан тушаалтан бөгөөд эцсийн өмчлөгч нь Топ моторс ХХК-ийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий албан тушаалтан байх ба Топ моторс ХХК-ийн 100% хувьцааг М СИ ЭС холдинг ХХК эзэмшиж байна. Юнител ХХК, Топ моторс ХХК болон М СИ ЭС холдинг ХХК нь нэг эцсийн өмчлөгчтэй хуулийн этгээдүүд байна.

- Олон суваг дамжуулах үйлчилгээ (ОСДҮ) эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд болон радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдүүд нэг толгой компанид хамаарч, нэг эцсийн өмчлөгчтэй байгаа тохиолдол: Зураг 8

Зураг-8.

4. ОСДҮ ба Арилжааны радио:



Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т Хуулийн этгээд нь өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний дараах төрлийн тусгай зөвшөөрлийн нэгээс илүүг буюу давхар эзэмшихийг хориглоно:

- 18.1.1.радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ;
- 18.1.2.олон суваг дамжуулах үйлчилгээ;


- 18.1.3. өргөн нэвтрүүлгийн радио, телевизийн үйлчилгээ гэж зохицуулсан байдаг.

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн эзэмшлийн мэдээлэл, эцсийн өмчлөгчийн хэлхээ холбоог судалж хэт төвлөрлийн өнөөгийн нөхцөл байдлын судалгааг гаргалаа. Үүнд:

1. Олон суваг дамжуулах үйлчилгээ (ОСДҮ) эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдүүд нэг толгой компанид хамаарч, нэг эцсийн өмчлөгчтэй байгаа тохиолдол: Зураг 9

Зураг-9.


1. ОСДҮ-1 ба ОСДҮ-2:



2. Өргөн нэвтрүүлгийн телевиз (ӨНТВ)-ийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдүүд нэг толгой компанид хамаарч, нэг эцсийн өмчлөгчтэй байгаа тохиолдол: Зураг-10

Зураг-10.

2. ӨНТВ-1 ба ӨНТВ-2:



Өнөөгийн нөхцөл байдлыг дүгнэн үзэхэд тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн шууд эзэмшлийн тухайд хуульд заасан шаардлагыг хангасан буюу хууль зөрчөөгүй байгаа хэдий ч хуулийн этгээдийн эзэмшил, эцсийн өмчлөгчийн хэлхээ холбоо, компанийн нэгдлийн хэмжээнд өргөсгөсөн хүрээнд судалж үзэхэд дээрх тохиолдлууд илэрч байгааг цаашид анхаарч үзэх нь зүйтэй юм.

2.3. Өргөн нэвтрүүлгийн эзэмшил, эрх бүхий этгээдэд орсон өөрчлөлтийн нөхцөл байдал (2025 оны эзэмшлийн мэдээллийн хүрээнд орсон өөрчлөлт)

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн “Гаргасан хувьцааных нь тав ба түүнээс дээш хувийг эзэмшдэг хувьцаа эзэмшигч болон компанийн эрх бүхий албан тушаалтан өөрчлөгдсөн тохиолдолд өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч нь энэ тухай 30 хоногийн дотор Зохицуулах хороонд бичгээр, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэнэ” гэж заасан. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний хүрээнд хуулийн этгээдийн эзэмшил, компанийн эрх бүхий албан тушаалтны мэдээллийг жил бүрийн

12-р сарын 31-ний байдлаар гаргуулан авч үнэлэлт дүгнэлт гаргах нь чухал ач холбогдолтой ч тэдгээрт орж байгаа өөрчлөлтийн мэдээллийг тухай бүр мэдэгдэх үүргийг үйлчилгээ эрхлэгчдэд хуулиар хүлээлгэсэн байдаг. Ингэснээр өрсөлдөөнийг хязгаарлаж, төвлөрөл үүсгэх аливаа үйлдлээс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэх боломжтой гэж үзсэн байдаг. Олон улсад аливаа өөрчлөлт оруулахаас өмнө зохицуулах байгууллага, өрсөлдөөний асуудал эрхэлсэн байгууллагаас дүгнэлт гаргуулан авах замаар эзэмшилд өөрчлөлт оруулах зарчмыг тогтоосон байдаг. Харин Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар эзэмшилд өөрчлөлт орсны дараа зохицуулах хороонд мэдэгдэж, зохицуулах хороо тэдгээр мэдээлэлтэй танилцаад өргөн нэвтрүүлгийн салбарт шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, зах зээлийн хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэхэд чиглэсэн шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр зохицуулсан.

Эзэмшлийн мэдээллийн өөрчлөлтөд тогтмол хяналт тавьснаар өргөн нэвтрүүлгийн эзэмшил, зах зээлийн төвлөрлийн нөхцөл байдлын өөрчлөлтөд үнэлэлт дүгнэлт гаргах боломжтойгоос гадна салбарт хийгдэж байгаа хөрөнгө оруулалт, компанийн засаглал, бүтцийн өөрчлөлтийн хөдөлгөөнийг тодорхойлох, зах зээлийн судалгааны суурь мэдээлэл бүрдэх ач холбогдолтой байдаг.

Өргөн нэвтрүүлгийн эзэмшил, эрх бүхий этгээдэд орсон өөрчлөлтийн нөхцөл байдлыг 2025 оны эзэмшлийн мэдээллийн хүрээнд судалж үзэхэд:

1. Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн эзэмшил, компанийн эрх бүхий албан тушаалтан өөрчлөгдсөн байдал: Хүснэгт 10

Хүснэгт-10.

ТВ нэр	Хуулийн этгээдийн хувьцаа, эзэмшил		Итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээд		Тайлбар
	Өмнө нь	Орсон өөрчлөлт	Өмнө нь	Орсон өөрчлөлт	Хуулийн этгээдийн эзэмшилд орсон хөдөлгөөн
TB8	Суваг ти ви найм ХХК (ХЭ: Эрхэт Монгол ХХК (ХЭ: Х.Мандахбаяр-49%, Н.Гантуяа-51%))	Суваг ти ви найм ХХК (ХЭ: Эрхэт Монгол Медиа Холдинг ХХК (ХЭ: Эрхэт монгол групп ХХК 100% (ХЭ: Х.Мандахбаяр-100%)))	М.Одгэрэл	Х.Мандахбаяр	1 хасагдаж, 1 хүний эзэмшилд шилжсэн
NTV	Эн Ти Ви Бродкастинг ХХК - (ХЭ: М.Есөнмөнх-8.51%, Медиа групп ХХК-91.49%)	Эн Ти Ви Бродкастинг ХХК - (ХЭ: Медиа групп ХХК-100%)			1 хасагдаж, 1 компанийн эзэмшилд шилжсэн
Малчин			П.Түвшин	С.Жаргал	Гүйцэтгэх захирал өөрчлөгдсөн
DBS TV	Дархан мэдээлэл төв ХХК (ХЭ: Б.Жавхлан 100%)	Дархан мэдээлэл төв ХХК (ХЭ: Ц.Батсуурь 100%)			1 хасагдаж, 1 нэмэгдсэн - Эзэмшил бүхэлдээ өөрчлөгдсөн
RGB TV	Аа Жи Би Ти Виз ХХК (ХЭ: Б.Мягмардаш 100%)	Аа Жи Би Ти Виз ХХК (ХЭ: Б.Мандах 100%)	Б.Отгонбаяр	С.Мөнхтуяа	1 хасагдаж, 1 нэмэгдсэн - Эзэмшил бүхэлдээ өөрчлөгдсөн

2. Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн эзэмшил, компанийн эрх бүхий албан тушаалтан өөрчлөгдсөн байдал: Хүснэгт 11

Хүснэгт-11

ТВ нэр	Хуулийн этгээдийн хувьцаа, эзэмшил		Итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээд		Тайлбар
	Өмнө нь	Орсон өөрчлөлт	Өмнө нь	Орсон өөрчлөлт	Хуулийн этгээдийн эзэмшилд орсон хөдөлгөөн
Парламентын суваг			Г.Содбаяр	Ч.Гэрэл	Гүйцэтгэх захирал өөрчлөгдсөн
Channel11			На.Гантуяа	Ня.Гантуяа	Гүйцэтгэх захирал өөрчлөгдсөн
Өлзий телевиз	Өлзий медиа ХХК (ХЭ: Ж.Баяр, Л.Нямдаваа, Б.Нармандах, Г.Итгэл, А.Аюур, Д.Отгонзаяа, Б.Сайнбаяр, Б.Батхүү)	Өлзий медиа ХХК (ХЭ: Г.Мөнхбаяр 100%)	Г.Итгэл	Г.Мөнхбаяр	8 хасагдаж, 1 нэмэгдсэн – Эзэмшил бүхэлдээ өөрчлөгдсөн
MNC	Лейди чаннел ХХК (ХЭ: Г.Мөнхтуяа-75%, С.Отгонмөнх-25%)	Лейди чаннел ХХК (ХЭ: Лариско медиа групп ХХК (ХЭ Э.Долгион, Ц.Эрдэнэбаяр))	Б.Ган-Эрдэнэ	Ц.Пүрэвжаргал	2 хасагдаж, 1 нэмэгдсэн - Эзэмшил бүхэлдээ өөрчлөгдсөн
LIVE	Дэлхийн чимээ медиа групп ХХК (ХЭ: Д.Отгонжаргал 100%)	Дэлхийн чимээ медиа групп ХХК (ХЭ: Б.Тэмүүлэн 100%)			1 хасагдаж, 1 нэмэгдсэн - Эзэмшил бүхэлдээ өөрчлөгдсөн
Хөгжил телевиз	Хөгжил телевиз ХХК (ХЭ: Д.Мөнхтөр-50%, Ц.Баярмаа-50%)	Хөгжил телевиз ХХК (ХЭ: Д.Мөнхтөр 100%)			1 хасагдаж, 1 хүний эзэмшилд шилжсэн
Гандан ТВ	Жи суваг ХХК (ХЭ: Монголын Бурхан Шашинтны төв-Гандантэгчэнлин хийд 100%)	Жи суваг ХХК (ХЭ: Монголын патент экскенж ХХК 100%)	П.Мөнх-Очир	Г.Ган-Эрдэнэ	1 хасагдаж, 1 нэмэгдсэн - Эзэмшил бүхэлдээ өөрчлөгдсөн
News channel	Маст технологи ХХК (ХЭ: Байлинк ХХК (ХЭ: Сууббо ХХК (ХЭ: У.Ундармаа 100%)))	Маст технологи ХХК (ХЭ: С.Ганбат 100%)	С.Ганбат	Э.Дөлгөөн	1 хасагдаж, 1 нэмэгдсэн - Эзэмшил бүхэлдээ өөрчлөгдсөн
Bantan	Трионикс мета вишн ХХК (ХЭ: А.Дөлгөөн 100%)	Трионикс мета вишн ХХК (ХЭ: Б.Одбаяр 100%)	А.Дөлгөөн	Б.Одбаяр	1 хасагдаж, 1 нэмэгдсэн - Эзэмшил бүхэлдээ өөрчлөгдсөн

3. Арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн эзэмшил өөрчлөгдсөн байдал: Хүснэгт 12

Хүснэгт-12

Радиогийн нэр	Хуулийн этгээдийн хувьцаа, эзэмшил		Итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээд		Тайлбар
	Өмнө нь	Орсон өөрчлөлт	Өмнө нь	Орсон өөрчлөлт	Хуулийн этгээдийн эзэмшилд орсон хөдөлгөөн
Бизнес радио FM-98.9	Монголиан Мюзик Медиа ХХК (ХЭ: А.Орхон 100%)	Монголиан Мюзик Медиа ХХК (ХЭ: Ц.Нацагдорж 100%)	А.Орхон	Ц.Нацагдорж	1 хасагдаж, 1 нэмэгдсэн - Эзэмшил бүхэлдээ өөрчлөгдсөн
Формула FM-98.1	Радиоком Монгол ХХК (ХЭ: Д.Батманлай 100%)	Радиоком Монгол ХХК (ХЭ: Э.Ууганбаяр 100%)	Д.Батманлай	Э.Ууганбаяр	1 хасагдаж, 1 нэмэгдсэн - Эзэмшил бүхэлдээ өөрчлөгдсөн
Их Монгол FM-99.7	Дижитал радио ХХК (ХЭ: Ч.Даваабаяр, Б.Энх-Амгалан)	Дижитал радио ХХК (ХЭ: Э.Мөнгөнцацрал 100%)	О.Цацрал	Э.Мөнгөнцацрал	2 хасагдаж, 1 нэмэгдсэн - Эзэмшил бүхэлдээ өөрчлөгдсөн
Хамаг Монгол FM-95.1	Шүхэр НҮТББ (ХЭ: Б.Шиараврилдий 100%)	Шүхэр НҮТББ (ХЭ: Э.Батзориг 100%)	Б.Бямбадэлгэр Б.Шиараврилдий	Б.Бямбадэлгэр Э.Батзориг	1 хасагдаж, 1 нэмэгдсэн - Эзэмшил бүхэлдээ өөрчлөгдсөн
Монголчуудын радио FM-102.1	Эм Эс Жи Эм Эл ХХК (ХЭ: Б.Энхцацрал 100%)	Эм Эс Жи Эм Эл ХХК (ХЭ: С.Маралмаа 100%)			1 хасагдаж, 1 нэмэгдсэн - Эзэмшил бүхэлдээ өөрчлөгдсөн
VIP радио FM-90.5	Манай аялгуу Эф Эм Ар ХХК (ХЭ: Улаанбаатар телевиз ХХК 100%)	Манай аялгуу Эф Эм Ар ХХК (ХЭ: Э.Баасандорж 75.5%, Буряад ТВ (Автономная некоммерческая организация, ЭЛ № ФС 77 – 80158 - Роскомнадзор) 24.5%)	Л.Балжжав	Э.Баасандорж	1 хасагдаж, 2 нэмэгдсэн - Эзэмшил бүхэлдээ өөрчлөгдсөн

4. Төлбөртэй телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн эзэмшил, компанийн эрх бүхий албан тушаалтан өөрчлөгдсөн байдал: Хүснэгт 13

Хүснэгт-13.

ТВ нэр	Хуулийн этгээдийн хувьцаа, эзэмшил		Итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээд		Тайлбар
	Өмнө нь	Орсон өөрчлөлт	Өмнө нь	Орсон өөрчлөлт	Хуулийн этгээдийн эзэмшилд орсон хөдөлгөөн
MN+	Скайтел ХХК (ХЭ: Шунхлай холдинг ХХК 50%, Алтай холдинг ХХК 37.97%, С.Батболд 12%)	Скайтел ХХК (ХЭ: Шунхлай холдинг ХХК 100%)	Г.Амарчингун	П.Батсайхан Г.Амарчингун	2 хасагдаж, 1 компанийн эзэмшилд шилжсэн

5. Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн эзэмшил өөрчлөгдсөн байдал: Хүснэгт 14

Хүснэгт-14.

ОСДҮ нэр	Хуулийн этгээдийн хувьцаа, эзэмшил		Итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээд		Тайлбар
	Өмнө нь	Орсон өөрчлөлт	Өмнө нь	Орсон өөрчлөлт	
MNBC	Эн Би Си ХХК (ХЭ: С.Ганбат 100%)	Эн Би Си ХХК (ХЭ: Айдиа Легаси Капитал ХХК 75%, Э.Буянтогтох 15%, Н.Ариун-Эрдэнэ 10%)	С.Эрхэмбат	Ж.Золбат	1 хасагдаж, 3 нэмэгдсэн – Эзэмшил бүхэлдээ өөрчлөгдсөн

Өргөн нэвтрүүлгийн эзэмшил, эрх бүхий этгээдэд орсон өөрчлөлтийн нөхцөл байдлыг 2025 оны эзэмшлийн мэдээллийн хүрээнд нэгтгэн дүгнэхэд УБ хотод үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 6 радио, мөн дараах 8 телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн ЭЗЭМШИЛ БҮХЭЛДЭЭ өөрчлөгдсөн байна:

- Орон нутагт өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй – 2 телевиз
- МУ-д арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй – 4 телевиз
- УБ-т арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй – 2 телевиз.

Хуулийн этгээдийн эзэмшил НЭГ ЭТГЭЭДЭД ТӨВЛӨРӨХ байдлаар өөрчлөгдсөн буюу нэг эзэмшилтэй болсон 1 радио, 3 телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд байгаа ба 2 телевизийн хувьд МУ-д хамрах хүрээтэй өргөн нэвтрүүлгийн телевизийн тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд, үлдсэн № телевизийн хувьд МУ-д хамрах хүрээтэй арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд тус тус байна.

Итгэмжлэлгүйгээр төлөөлөх ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД өөрчлөгдсөн тохиолдол МУ-д хамрах хүрээтэй өргөн нэвтрүүлгийн 2 телевиз, орон нутгийн 1 өргөн нэвтрүүлгийн телевиз, арилжааны 7 телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдэд бүртгэгдсэн бол арилжааны 5 радиогийн үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд бүртгэгдсэн байна.

Дүгнэлт:

Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд заасан өргөн нэвтрүүлгийн эзэмшил, хэт төвлөрлөөс сэргийлэхтэй холбоотой зохицуулалтын хэрэгжилтийн байдалд хийсэн энэхүү үнэлгээ, судалгаанаас үзэхэд Монгол Улсын өргөн нэвтрүүлгийн салбарын эзэмшлийн бүтэц нь гаднаас харахад олон үйлчилгээ эрхлэгчтэй мэт боловч эцсийн өмчлөгч, хамаарал бүхий этгээдийн түвшинд авч үзвэл хэд хэдэн үйлчилгээ нэг эзэмшлийн хүрээнд бүртгэгдсэн, төвлөрөх хандлага ажиглагдаж байна. Ялангуяа охин, хараат компани болон холбогдох этгээдээр дамжуулан телевиз, радио, төлбөртэй телевиз, олон суваг дамжуулах үйлчилгээ зэрэг өөр өөр төрлийн үйлчилгээг нэг бүлэглэл эзэмших тохиолдлууд байгаа нь зөвхөн тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн түвшинд үнэлгээ хийх нь хангалтгүй болохыг харуулж байна.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд эзэмшлийн ил тод байдлыг хангах, давхар эзэмшлийг хязгаарлах, хэт төвлөрлөөс урьдчилан сэргийлэх зохицуулалтыг тусгасан боловч тэдгээрийн хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт, зах зээлийн төвлөрлийг тодорхойлох аргачлал, эзэмшлийн төвлөрлийн босго үзүүлэлт хууль тогтоомжид тодорхой тусгагдаагүй байна. Мөн Өрсөлдөөний тухай хууль нь эдийн засгийн өрсөлдөөнийг хамгаалахад чиглэсэн ерөнхий зохицуулалттай бөгөөд хэвлэл мэдээллийн салбарын онцлог болох олон ургалч үзэл, мэдээллийн хараат бус байдал, иргэдийн мэдэх эрхэд үзүүлэх нөлөөллийг тусгайлан үнэлэх эрх зүйн үндэс хангалтгүй байна. Иймээс өргөн нэвтрүүлгийн салбар дахь төвлөрлийг зөвхөн зах зээлд эзлэх хувиар бус, агуулгын олон талт байдал, редакцын хараат бус байдал, мэдээллийн хүртээмжид үзүүлэх нөлөөллийн хамт үнэлэх шаардлагатай байна.

Нөгөө талаас дижитал технологийн хөгжил, ОТТ болон шинэ төрлийн медиа үйлчилгээ эрчимтэй хөгжиж буй өнөөгийн нөхцөлд зах зээлийн хил хязгаар, хэрэглэгчийн тооцоолол, орлогын бүтэц, эцсийн өмчлөгчийн хэлхээ холбоог тодорхойлох нь улам бүр төвөгтэй болж байна. Иймд өргөн нэвтрүүлгийн эзэмшил, төвлөрлийн судалгааг жил бүр тогтмол хийж, суурь мэдээллийн сан бүрдүүлэх, төрийн байгууллагууд хоорондын мэдээлэл солилцоог сайжруулах, цахим хэлбэрээр хайлт, шинжилгээ хийх боломжтой нээлттэй мэдээллийн санг хөгжүүлэх, судалгааны үр дүнг ил тод, хүртээмжтэй мэдээлэх тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байна. Үүний зэрэгцээ өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлд шударга өрсөлдөөнийг хангах, эзэмшил, зах зээлийн төвлөрлийг үнэлэх аргачлал, шалгуур үзүүлэлт, зохицуулалтын хамрах хүрээг олон улсын чиг хандлага, шилдэг туршлагад нийцүүлэн боловсронгуй болгох нь цаашдын эрх зүйн шинэчлэлийн чухал чиглэл гэж үзэж байна.

Харилцаа холбооны зохицуулах хороо нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 19.1-д заасан “өргөн нэвтрүүлгийг хараат бус, нээлттэй, ёс зүйтэй байлгах зорилгоор өргөн нэвтрүүлгийн эзэмшлийг ил тод байлгах” зохицуулалтын хэрэгжилтийг хангах хүрээнд өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшил, өмчлөлийн мэдээллийг жил бүр шинэчлэн гаргуулж, олон нийтэд ил тод мэдээлж байна. Үүнээс гадна салбарын эзэмшил, давхар эзэмшил, гадаадын хөрөнгө оруулалт, тэдгээрийн зах зээлийн төвлөрлийн нөхцөл байдалд судалгаа, үнэлгээ хийж, түүний үр дүнг олон нийтэд нээлттэй мэдээлэх замаар ил тод байдал, хариуцлагатай зохицуулалтын тогтолцоог бэхжүүлэн ажиллаж байна.

Энэхүү судалгаа, үнэлгээ нь өргөн нэвтрүүлгийн эзэмшлийг ил тод байлгах, өргөн нэвтрүүлгийг хараат бус, нээлттэй, ёс зүйтэй байлгах зорилтын хүрээнд өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшил, өмчлөлийн бүтэц, тэдгээрийн зах зээлийн нөхцөл байдалтай холбоотой суурь мэдээллийг нэгтгэн үнэлсэн болно. Үнэлгээ нь зах зээлд эзэмшлийн хэт төвлөрөл үүссэн талаар эцсийн дүгнэлт гаргах зорилготой бус бөгөөд эзэмшлийн бүтэцтэй хамт зах зээлийн эзлэх хувь, үйлчилгээний хамрах хүрээ, агуулгын олон талт байдал, редакцын хараат бус байдал, үзэгч, сонсогчийн хүртээмж зэрэг олон хүчин зүйлийг цогцоор нь үнэлэх шалгуур үзүүлэлт, хууль эрх зүйн хувьд тодорхой болгох зүйл заалт цаашид

шаардлагатайг тодорхойлсон болно. Судалгааны үр дүн нь өргөн нэвтрүүлгийн салбарын ил тод байдлыг нэмэгдүүлэх, цаашид эзэмшлийн төвлөрлөөс урьдчилан сэргийлэх, шаардлагатай тохиолдолд зохицуулалтын арга хэмжээ, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход ашиглах суурь мэдээлэл, үнэлгээний үндэс болно гэж үзэж байна.

Ашигласан мэдээлэл, эх сурвалж:

- Улсын бүртгэлийн ерөнхий газрын нээлттэй мэдээллийн сангийн Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэл - <https://opendata.burtgel.gov.mn/>
- Харилцаа холбооны зохицуулах хорооноос гаргасан өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн 2025 оны эзэмшлийн талаарх мэдээлэл - <https://www.crc.gov.mn/rg-n-nevtr-leg/ezemsliin-medeellin-il-tod-baidal/2025-onii-ezemsliin-medeelel>
- Харилцаа холбооны зохицуулах хорооноос өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн жагсаалт, мэдээлэл – <https://www.crc.gov.mn/rg-n-nevtr-leg/tusgai-zovsoorol-2/zovsoorol-ezemsigcdiin-zagsaalt>
- Харилцаа холбооны зохицуулах хорооноос гаргасан өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн эзэмшил, өмчлөлийн ил тод байдлын аналитик судалгаа (2025 оны эзэмшлийн мэдээллийн хүрээнд гаргасан судалгаа) - <https://www.crc.gov.mn/rg-n-nevtr-leg/ezemsliin-medeellin-il-tod-baidal/2025-onii-ezemsliin-medeelel>

---ooOoo---